



“ТЭД-АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 хороолол,
6-р хороо, Их сургуулийн гудамж 40 байр, 7 тоот
tedaudit96@gmail.com
+976-99190483, +976-11350953

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Ариг гал” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлангийн аудит



Улаанбаатар хот
2026 он

ТЭД-АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан дүгнэлт

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ариг гал” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид “Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл”-ийн “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм” болон Монгол улса мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгч байгууллагаас хараат бус ажилласан болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой, зохистой гэж итгэж байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй бөгөөд байгууллага үйл ажиллагаагаа цаашид хэвийн, тасралтгүй явуулна гэсэн төсөөллөөр санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмж шийдлээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөлөл үзүүлэх зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт” бусад холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн бэлтгэж, үнэн зөв толилуулах түүнчлэн алдаа болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага

Бид хийж гүйцэтгэсэн аудитын ажилд үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад хараат бус дүгнэлт өгөх нь аудиторовн үүрэг юм. Бид аудитын ажлаа “Аудитын Олон Улсын Стандарт”-ын дагуу хийж гүйцэтгэдэг бөгөөд эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авахын тулд аудитын ажлыг төлөвлөж, гүйцэтгэх зохих шаардлагуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

АОУС-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэхдээ мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг болно.

Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Мөн бид:

- Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх,

санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Тэдгээр эрсдлүүдийн үнэлгээг хийхдээ байгууллагын тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлох, боловсруулах зорилгоор дотоод хяналтын талаар ойлголт олж авах бөгөөд харин дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилго агуулахгүй.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийлэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Санхүүгийн тайлангийн хэрэглээ

Энэхүү аудитын тайланг үйлчлүүлэгч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн тул тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиторын тайлан нь үндсэн тайлангууд болон тодруулга хэсгүүдээс бүрдэх болно.

“ТЭД-АУДИТ” ХХК

ТЭД-АУДИТ
ХХК-АУДИТ

ЗАХИРАЛ ТА 5627-А 2026-04

В.ОЮУНЧИМЭГ

2026 оны 04-р сарын 28-нд

"АРИГ ГАЛ" ХК**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН****2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар****(төгрөгөөр)**

ХӨРӨНГӨ	2024.12.31	2025.12.31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,556,016,702.89	452,670,848.76
Дансны авлага	78,967,939,775.86	99,453,182,063.32
Татвар, НДШ-ийн авлага	275,713,693.00	136,988,031.36
Бусад авлага		
Бараа материал	26,926,237.79	26,926,237.79
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		
Эргэлтийн хөрөнгийн дүн	80,826,596,409.54	100,069,767,181.23
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,296,583,030.70	2,173,200,067.50
Биет бус хөрөнгө	13,358,718.68	11,722,957.16
Хайгуул үнэлгээний хөрөнгө	509,333,043.12	509,333,043.12
Бусад эргэлтийн бус хөрөнгө	18,474,485,538.25	18,495,721,514.25
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,293,760,330.75	21,189,977,582.03
НИЙТ ХӨРӨНГӨ	102,120,356,740.29	121,259,744,763.26

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	82,136,721,683.03	98,827,217,271.72
Цалингийн өглөг	18,880,332.35	36,159,046.40
Татварын өглөг	6,413,246.03	21,750,392.42
НДШ-ийн өглөг		
Богино хугацаат зээл		
Нөөц өр төлбөр	3,509,320,183.68	2,903,675,004.47
Урьдчилж орсон орлого	391,101.58	391,101.58
Богино хугацаат өр төлбөрийн дүн	85,671,726,546.67	101,789,192,816.59
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр	1,153,229,870.90	1,104,964,370.90
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,153,229,870.90	1,104,964,370.90
Өр төлбөрийн нийт дүн	86,824,956,417.57	102,894,157,187.49
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	347,932,000.00	347,932,000.00
Халаасны хувьцаа	(25,890,800.00)	(26,158,800.00)
Нэмж төлөгдсөн капитал	(528,915,453.70)	(541,191,029.70)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,683,611,872.05	6,683,611,872.05
Хуримтлагдсан ашиг	8,818,662,704.37	11,901,393,533.42
Эзэмшигчдийн өмчийн дүн	15,295,400,322.72	18,365,587,575.77
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	102,120,356,740.29	121,259,744,763.26

"АРИГ ГАЛ" ХК

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2024.12.31	2025.12.31
Борлуулалтын орлого		
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг (алдагдал)	0.00	0.00
Түрээсийн орлого	1,113,583,241.68	1,444,920,964.58
Хүүний орлого	49,221,079.91	58,882,371.20
Ногдол ашгийн орлого	12,639,791,213.10	14,916,059,520.00
Үйл ажиллагааны зардал	1,890,926,705.72	2,075,685,683.79
Үйл ажиллагааны бус зардал	7,864,654,692.41	10,364,931,941.76
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Бусад ашиг, (алдагдал)		
Татварын төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,047,014,136.56	3,979,245,230.23
Орлогын татварын зардал	1,268,901,229.29	751,691,213.12
Татварын дараах ашиг (алдагдал)	2,778,112,907.27	3,227,554,017.11
Цөөнхөд ногдох хувь		
Цэвэр ашиг (алдагдал)	2,778,112,907.27	3,227,554,017.11

"АРИГ ГАЛ" ХК

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	347,932,000.00	(21,469,300.00)	(394,512,743.70)	6,683,611,872.05	6,298,209,477.10	12,913,771,305.45
Тайлант хугацаанд нэмэгдсэн		(4,421,500.00)	(134,402,710.00)			(138,824,210.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
Залруулсан үлдэгдэл	347,932,000.00	(25,890,800.00)	(528,915,453.70)	6,683,611,872.05	6,298,209,477.10	12,774,947,095.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					2,778,112,907.27	2,778,112,907.27
Зарласан ногдол ашиг					(257,659,680.00)	(257,659,680.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	347,932,000.00	(25,890,800.00)	(528,915,453.70)	6,683,611,872.05	8,818,662,704.37	15,295,400,322.72
Тайлант хугацаанд нэмэгдсэн		(268,000.00)	(12,275,576.00)			(12,543,576.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
Залруулсан үлдэгдэл	347,932,000.00	(26,158,800.00)	(541,191,029.70)	6,683,611,872.05	8,818,662,704.37	15,282,856,746.72
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					3,227,554,017.11	3,227,554,017.11
Зарласан ногдол ашиг					(144,823,188.06)	(144,823,188.06)
Хувьцаат капиталын өсөлт						-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	347,932,000.00	(26,158,800.00)	(541,191,029.70)	6,683,611,872.05	11,901,393,533.42	18,365,587,575.77



"АРИГ ГАЛ" ХК

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(төгрөгөөр)	
	2024.12.31	2025.12.31
Бараа, ажил үйлчилгээний болон бусад мөнгөн орлого	36,004,995,814.82	972,753,068.16
Бараа материал худалдан авахад төлсөн болон бусад мөнгөн зарлага	1,290,207,799.26	817,359,099.82
Ажиллагсдад олгосон мөнгө	277,602,947.00	260,101,676.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,752,000.00	59,000,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	5,173,410.00	3,316,954.55
Ашиглалтын зардалд төлсөн		6,566,842.17
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,944,524.00	6,806,300.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	211,853,772.41	124,813,507.77
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	717,881,145.85	356,753,819.33
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	34,714,788,015.56	155,393,968.34

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн	11,375,812,091.80	14,225,326,251.81
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан ногдол ашиг	11,375,812,091.80	14,170,256,544.00
Хүлээн авсан хүүний орлого		55,069,707.81
Мөнгөн зарлагын дүн	610,909.09	0.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	610,909.09	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	11,375,201,182.71	14,225,326,251.81

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ

Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан болон бусад орлого		6,600,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөр, ногдол ашигт төлсөн мөнгө	46,554,613,000.00	22,084,066,074.28
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(46,554,613,000.00)	(15,484,066,074.28)
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(464,623,801.73)	(1,103,345,854.13)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,020,640,504.62	1,556,016,702.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,556,016,702.89	452,670,848.76

Эдгээр тодруулгууд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр: "Ариг гал" ХХК

Регистрийн дугаар: 2075768

Үйл ажиллагааны чиглэл: Барилгын засвар хийх, барилгын материалын худалдаа, Худалдааны зуучлал, Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн түрээс, Гадаад худалдаа, Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл /2015.01.28-2045.01.28/

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

Тус байгууллага нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараахь бүртгэлийн бодлогуудыг баримталдаг.

2.1 Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал, тайлант жилд гарсан онцлох өөрчлөлтүүд

Тус байгууллагын 2025 оны Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна. Байгууллага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, тодруулгуудыг бэлтгэсэн байна.

2.2 Санхүүгийн тайлагналын суурь

Байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, аккрузл сууриар бэлтгэгдсэн байна.

2.3 Санхүүгийн тайланг бэлтгэсэн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайланг байгууллагын үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох Монгол улсын төгрөгөөр илэрхийлсэн.

2.4 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

2.5 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн гадаад валют болон суурь валютын хоорондох валютын ханшийг ашиглаж, гадаад валютын дүнг суурь валютад хөрвүүлэн анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэдэг.

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Хөрвүүлэлтээс үүдсэн ханшийн зөрүүг орлогын тайланд бүртгэнэ. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдэд хамааралтай гадаад валютаарх ашиг, алдагдал дэлгэрэнгүй орлогын тайланд бусад орлогын хэлбэрээр толилуулна.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлнэ.

2.6 Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого

Санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримталдаг байна.

2.6.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь төгрөгийн касс болон банкин дахь төгрөг, валют, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг.

Мөнгөн хөрөнгийн нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлийг балансын өдрөөрх Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг

2.6.2 Санхүүгийн хэрэгсэлүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад бэлэн мөнгө, богино хугацаат хадгаламж, дансны авлага болон бусад авлага өглөгөөс бүрдэнэ.

Санхүүгийн хөрөнгүүдийг эхлэж бодит үнэ цэнээр нь бүртгэх ба бүх худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь, зээл болон зээллэгийг шууд хамааралтай зээлийн зардлын нийлбэр дүнгээр хүлээн зөвшөөрнө. Байгууллагын санхүүгийн өр төлбөрт дансны өглөг, бусад өглөг, зээл, зээлийн хүүгийн өглөг багтана.

Авлага

Зээл болон авлага нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл биш санхүүгийн хөрөнгө юм.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө үйлчлүүлэгчээс авах авлагын дүн орно.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

НДШ-ийн авлага, ХХОАТатвар, төлбөр, хураамжийн болон НӨАТ-ийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татварын авлагын дүн нь татварын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

2.6.3 Бараа материал

Бараа материалын өртөг нь бараа материалыг худалдан авсан өртгөөр тодорхойлогддог. Бараа материалыг дундаж өртөгийн аргаар зарлага болгож, бүртгэлийн байнгын системээр бүртгэнэ.

2.6.4 Орлого

Эдийн засгийн үр ашиг нь байгууллагад орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед хүлээн зөвшөөрнө.

2.6.5 Зардал

Санхүүгийн хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар эдийн засгийн үр өгөөж буурах ба түүнийг бодитой хэмжих боломжтой үед зардлыг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Касс дахь бэлэн мөнгө	71,316,165.33	64,744,893.85
Бэлэн мөнгөний үлдэгдэл	71,316,165.33	64,744,893.85
Банкин дахь мөнгө	1,484,700,537.56	387,925,954.91
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	1,484,700,537.56	387,925,954.91
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	1,556,016,702.89	452,670,848.76

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө 452,670.8 мян/төг-ийн үлдэгдэлтэй байна. Бэлнээр болон Хаан, Хас, Голомт, Капитрон банкууд дахь харилцах дансдуудад үлдэгдлээр байна.

ТОДРУУЛГА 4. ДАНСНЫ БОЛОН БУСАД АВЛАГА

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Дансны авлага	78,967,939,775.86	38,031,915,505.02	17,546,673,217.56	99,453,182,063.32
Нийт авлагын дүн	78,967,939,775.86	38,031,915,505.02	17,546,673,217.56	99,453,182,063.32

Тайлант хугацаанд авлага 38,031,915.5 мян/төг-өөр нэмэгдэж 17,546,673.2 мян/төг-өөр буурч 99,453,182.1 мян/төг-ийн үлдэгдэлтэй байна. Нийт авлагын 97,407,843.4 мян/төг-ийн авлага нь Кашмер холдинг ХХК-наас авах авлага байна.

ТОДРУУЛГА 5. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
ААНОАТ-ын авлага	272,458,281.08	7,262,740.87	148,105,827.34	131,615,194.61
НДШ-ийн авлага	3,255,411.92	11,092,333.87	8,974,909.04	5,372,836.75
Нийт авлагын дүн	275,713,693.00	18,355,074.74	157,080,736.38	136,988,031.36

ТОДРУУЛГА 6. БАРАА МАТЕРИАЛ

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Хангамжийн материал	5,252,247.54			5,252,247.54
Бусад бараа материал	21,673,990.25			21,673,990.25
Нийт бараа материалын дүн	26,926,237.79	-	-	26,926,237.79

Ноосны будаг, сэлбэг, барилгын материал, хангамжийн материал зэрэг байна.

ТОДРУУЛГА 7. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Урьдчилж төлсөн зардал				-
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр				-
Нийт дүн	-	-	-	-

ТОДРУУЛГА 8. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө/

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө/				-
Нийт дүн	-	-	-	-

ТОДРУУЛГА 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлтүүд	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
ӨРТӨГ				
Барилга байгууламж	4,391,899,558.31			4,391,899,558.31
Машин тоног төхөөрөмж	7,141,965.86			7,141,965.86
Тээврийн хэрэгсэл	88,550,000.00			88,550,000.00
Тавилга эд хогшил	63,302,140.88			63,302,140.88
Компьютер, бусад хэрэгсэл	610,909.09			610,909.09
Дүн	4,551,504,574.14	-	-	4,551,504,574.14
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ				
Барилга байгууламж	2,132,720,965.42	114,882,963.24		2,247,603,928.66
Машин тоног төхөөрөмж	7,825,959.47			7,825,959.47
Тээврийн хэрэгсэл	50,574,999.85	8,499,999.96		59,074,999.81
Тавилга эд хогшил	63,799,618.70			63,799,618.70
Компьютер, бусад хэрэгсэл				-
Хуримтлагдсан элэгдлийн дүн	2,254,921,543.44	123,382,963.20	-	2,378,304,506.64
ЦЭВЭР ДҮН				
Барилга байгууламж	2,259,178,592.89			2,144,295,629.65
Машин тоног төхөөрөмж	(683,993.61)			(683,993.61)
Тээврийн хэрэгсэл	37,975,000.15			29,475,000.19
Тавилга эд хогшил	(497,477.82)			(497,477.82)
Компьютер, бусад хэрэгсэл	610,909.09			610,909.09
Үндсэн хөрөнгийн нийт дүн	2,296,583,030.70	-	-	2,173,200,067.50

Тайлант хугацаанд 123,383.0 мян/төг-ийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцсон байна. Үйлдвэрийн барилгын элэгдлийг тооцоходоо 40 жилээр тооцсон байна. Харин Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшилын хуримтлагдсан элэгдэл анхны өртгөөс хэтрэн үлдэх өртөг нь (-) үлдэгдэлтэй болсон байна. Тухайн хасах үлдэгдлийн залруулах.



ТОДРУУЛГА 10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Бусад биет бус хөрөнгө	13,358,718.68		1,635,761.52	11,722,957.16
Биет бус хөрөнгийн дүн	13,358,718.68	-	1,635,761.52	11,722,957.16

ТОДРУУЛГА 11. ХАЙГУУЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Хайгуул үнэлгээний хөрөнгө				-
ХҮХөрөнгийн дүн	-	-	-	-

ТОДРУУЛГА 12. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Дансны өглөг	82,136,721,682.98	46,324,649,768.36	29,634,154,179.62	98,827,217,271.72
Цалингийн өглөг	18,880,332.40	423,062,253.16	405,783,539.16	36,159,046.40
Бусад богино хугацаат өр төлбөр	3,509,320,183.68	503,846,570.79	1,109,491,750.00	2,903,675,004.47
Урьдчилж орсон орлого	391,101.58			391,101.58
НӨАТ-ын өглөг	4,187,821.57	151,739,831.79	155,927,653.36	-
ХХОАТ-ын өглөг	2,225,424.46	40,624,346.67	21,099,378.71	21,750,392.42
Нийт өр төлбөрийн дүн	85,671,726,546.67	47,443,922,770.77	31,326,456,500.85	101,789,192,816.59

Тайлант хугацаанд өр төлбөр 47,443,922.8 мян/төг-өөр нэмэгдэж 31,326,456.5 мян/төг-өөр буурч 101,789,192.8 мян/төг-ийн үлдэгдэлтэй байна. Нийт өр төлбөрийн 62,462,848.9 мян/төг нь "Тэргүүн-Оюун" ХХК-д, 32,464,792.8 мян/төг нь "Монноос" ХК-д, 1,860,135.9 мян/төг нь "Капитал лизинг" ХХК-д өгөх өглөг байна.

ТОДРУУЛГА 13 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Дансны нэрс	2024.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2025.12.31
Урт хугацаат өр төлбөр	1,153,229,870.90		48,265,500.00	1,104,964,370.90
Нийт өр төлбөрийн дүн	1,153,229,870.90	-	48,265,500.00	1,104,964,370.90

ТОДРУУЛГА 14. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
А. Өмч:		
Хувьцаат капитал	347,932,000.00	347,932,000.00
Халаасны хувьцаа	(25,890,800.00)	(26,158,800.00)
Нэмж төлөгдсөн капитал	(528,915,453.70)	(541,191,029.70)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,683,611,872.05	6,683,611,872.05
Өмчийн дүн	6,476,737,618.35	6,464,194,042.35
Б. Хуримтлагдсан ашиг (алдагдал)		
Тайлангийн үеийн ашиг (алдагдал)	2,778,112,907.27	3,227,554,017.11
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	6,040,549,797.10	8,673,839,516.31
Хуримтлагдсан ашиг(алдагдал)-ын дүн	8,818,662,704.37	11,901,393,533.42
Эзэмшигчдийн өмчийн дүн	15,295,400,322.72	18,365,587,575.77

Тайлант хугацаанд 3,227,554.0 мян/төг-ийн ашигтай ажилласан байна. Тайлант хугацаанд 144,823.2 мян/төг-ийн ногдол ашиг олгосон харагдаж байна.

ТОДРУУЛГА 15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Үндсэн үйл ажиллагааны борлуулалт	-	-
Борлуулалтын орлогын нийт дүн	-	-

ТОДРУУЛГА 16. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг	-	-
Борлуулалтын өртгийн нийт дүн	-	-

ТОДРУУЛГА 17. БУСАД ОРЛОГО

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Түрээсийн орлого	1,113,583,241.68	1,444,920,964.58
Хүүгийн орлого	49,221,079.91	58,882,371.20
Ногдол ашгийн орлого	12,639,791,213.10	14,916,059,520.00
Бусад орлогын нийт дүн	13,802,595,534.69	16,419,862,855.78

Түрээсийн орлого өмнө оноос 331,337.7 мян/төг-өөр, хүүгийн орлого 9,661.3 мян/төг-өөр, ногдол ашгийн орлого 2,276,268.3 мян/төг-өөр тус тус өссөн харагдаж байна.



ТОДРУУЛГА 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Цалин хөлс, шагнал	336,568,499.70	314,284,966.12
Нийгмийн даатгалын зардал	35,741,104.36	31,985,512.42
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	129,255,455.35	114,936,648.45
Томилолтын зардал	1,017,269.83	4,921,029.81
Шуудан холбооны зардал	4,296,636.55	5,296,175.47
Ашиглалтын зардал	972,090,807.19	1,065,457,046.41
Засварын зардал	6,336,454.54	19,546,545.45
Элэгдлийн зардал	124,556,212.80	124,556,212.80
Шатахууны зардал	8,707,579.19	7,018,484.75
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	272,356,686.21	387,683,062.11
Үйл ажиллагааны зардлын дүн	1,890,926,705.72	2,075,685,683.79

Үйл ажиллагааны зардал нь өмнө оноос 184,759.0 мян/төг-өөр өссөн байна. Ашиглалтын зардал 93,366.2 мян/төг-өөр, засварын зардал 13,120.1 мян/төг-өөр өссөн байна.

ТОДРУУЛГА 19. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Бусад зардал	7,864,654,692.41	10,364,931,941.76
Бусад зардлын дүн	7,864,654,692.41	10,364,931,941.76

ТОДРУУЛГА 20. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ/ГАРЗ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Гадаад валютын ханшийн тэгшгэлийн олз	-	-
Гадаад валютын ханшийн тэгшгэлийн гарз	-	-
Гадаад валютын ханшийн тэгшгэлийн олз (гарз)-ын дүн	-	-

ТОДРУУЛГА 21. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Дансны нэрс	2024.12.31	2025.12.31
Орлогын татварын зардал	1,268,901,229.29	751,691,213.12
Орлогын татварын зардлын дүн	1,268,901,229.29	751,691,213.12

Тайлант хугацаанд 751,691.2 мян/төг-ийн ААНОАТ-ын зардал тооцсон байна.


ТОДРУУЛГА 22. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн өдрөөс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

“ТЭД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн
гудамж 40-р байр 3 давхар 7 тоот
УБД: 2097141

Утас: 350953, 99190483

2026.04.27 № СТА/25-36

**“АРИГ ГАЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

УДИРДЛАГАД ТАНИЛЦУУЛАХ ЗАХИДАЛ

Бид танай компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлбар тодруулгуудад гэрээний дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитын тайланг хүргүүлж байна.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

Аудитыг хэрэгжүүлэх явцад бид тус байгууллагын дотоод хяналтын системийг үнэлэхтэй холбоотой горимуудыг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын системийн үр дүнтэй байгаа эсэх, залилан болон хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, хууль бус асуудлуудын талаар дүгнэлт өгөх зорилгыг агуулаагүй. Бидний аудитын явцад танай компанийн дотоод хяналтын зохион байгуулалт болон санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэг материаллаг алдаа илрүүлээгүй болно.

Биднийг аудит хийх үеэр хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн танай ажилтнуудад талархаж байгаагаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ

2026.04.27 нд



В.ОЮУНЧИМЭГ